

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-17

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт 4-7

2.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаар Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл сонсох, 3.Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны мэдээлэл сонсох 7-17

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
03 дугаар сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 06 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Батсуурь;
Чөлөөтэй: А.Адъяасүрэн, Ё.Баатарбилэг, Т.Доржханд, Г.Занданшатар,
Л.Оюун-Эрдэнэ, Б.Жаргалмаа, Ж.Сүхбаатар.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Н.Энхболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлэв.

Н.Энхболд: 1.Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд “сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй.” гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “... Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаар Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл сонсох, Гурав.Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны мэдээлэл сонсох

Байнгын хорооны дарга Н.Энхболд Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаар Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл, Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны мэдээллийг нэгтгэн хэлэлцэхийг мэдэгдэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, мөн хорооны Санхүүгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Оюунгэрэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэг, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга О.Ганбат, мөн газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дэд дарга Н.Амарсанаа, Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны тасгийн дарга М.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Р.Дүүрэнбаяр нар байлцав.

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны талаарх мэдээллийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нар танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 17 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 51 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжисин Д.Сүхбаатар”
танхим
17 цаг 06 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 24 оны 3 сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Байнгын хороогоор 3 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлт.

Хоёрт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаар Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэл сонсоно.

Гуравт нь Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны мэдээлэл сонсоно. Дэд хороо өчигдөр хуралдсан. Түүнийхээ дагуу Байнгын хороон дээр өнөөдөр мэдээлэл хийх юм.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.

Дэгээрээ, энэ ямар асуудал байгаа вэ гэхээр энэ Сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн

тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн энэ заалт нэмсэн нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг буюу жилийн дотор өөрчлөлт оруулж болохгүй гэсэн асуудлыг зөрчсөн байна гэж дүгнэлт гарсан. Үүнийг хэлэлцэх юм.

Улсын Их Хурлаас, Байнгын хорооноос итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон. Сандаг-Очир гишүүн ажилласан. Гишүүн өнөөдөр өөр ажилтай явж байгаа учраас би итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Цэцийн асуудалд тавьсан дүгнэлтэд өгсөн материалыг товчхон танилцуулъя.

Үндэслэл дээрээ Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан хууль дээдлэх зарчмын гол агуулга нь нийт байгууллага иргэний аливаа үйл ажиллагаанд Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байхын зэрэгцээ хуулийн хүрээнд явагдах агуулгыг илэрхийлнэ. Хууль дээдлэх зарчмын суурь болох Үндсэн хуулийг дээдлэх үзэл баримтлал нь дэлхий нийтийн түгээмэл эрхэм дээд үзэл санаа болон хүлээн зөвшөөрөгдсөн байна.

Хоёрт, Монгол Улсын 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын ээлжит сонгууль явахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж заасан нь сонгогч, иргэний төрийн үйл хэрэгт сонгож байгуулсан төрийн байгууллагын хараат уламжлан оролцох эрхийг баталгаажуулж сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн гарааны тэгш байдлыг хангах, Сонгуулийн хуулийг тогтвортой мөрдөхөд чиглэсэн байдаг. Ээлжит сонгууль явуулахын өмнө 1 жилийн хугацаанд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрөөгүй байна.

Гуравдугаарт нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр

зүйлийн 9.2 дахь хэсэгт ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн 6 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна гэж. Мөн хуулийн 82.1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрөөс өмнөх 1 жилийн хугацаанд Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж тус тус хуульчилсан.

Түүнчлэн Их Хурлаас Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай 23 оны 116 дугаар тогтоол гаргаад үүгээрээ ээлжит сонгуулийн санал авах өдрийг 24 оны 6 сарын 28-ны өдөр байхаар тогтоосон байсан.

Дээрхээс үзэхэд хууль тогтоогч 23 оны 7 сарын 7-ны өдөр буюу сонгууль явагдахын өмнөх 1 жилийн дотор Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийг баталсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн, хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс Цэц дүгнэлт ГАРГАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 сарын 7-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 21

дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахыг өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 24 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Энэ дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дахь зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай гэсэн Цэцийн 5 гишүүний бүрэлдэхүүнтэй болсон хуралдааны дүгнэлт ирсэн.

Даргалагч Эрдэнэбулган, гишүүд Туулхүү, Баясгалан, Гангабаатар, Энхтуяа гэсэн ийм дүгнэлт ирсэн байгаа.

Энэ дүгнэлтийг өнөөдөр Их хурлын Хууль зүйн байнгын хорооны хурлаар хэлэлцээд Цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэсэн санал дээр нэгдсэн шийдвэр гаргасан байгаа.

Саяын танилцуулга, Цэцийн дүгнэлт, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбараас асуулт асуух гишүүн байна уу? Сарангэрэл гишүүнээр тасаллаа.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Энэ Цэцийн дүгнэлт иргэдийн гомдлыг хүлээж аваад Их Хурал хууль зөрчсөн шийдвэр гарсан гэсэн ийм дүгнэлтийг хийж байгаа юм байна. Энэ манай Байнгын хороогоор ороогүй асуудал уу? Яагаад ийм хууль зөрчсөн асуудлыг Улсын Их Хурлын Байнгын хороо болон Улсын Их Хурал хэлэлцэж баталсан байх вэ? Хэрвээ үнэхээр ийм хууль зөрчсөн үйлдлийг Байнгын хорооны түвшинд, Их

Хурлын түвшинд хийсэн бол хариуцлага хэн хүлээх вэ? Дахин ийм зүйл давтан гаргахгүйн тулд бид яаж ажиллах ёстой вэ? Энэ дээр би Байнгын хорооны даргын байр суурийг сонсъё гэж бодож байна.

Н.Энхболд: Товчхон хариулъя. Бид нар 6 сарын 28-нд Улсын Их Хурлын сонгуулийн өдрийг товлон зарласан. Энэ хууль 7 сарын 7-ны өдөр өөрчлөлт орчихсон нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн асуудал байгаа юм гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Хоёрдугаарт, Төрийн байгуулалтын байнгын хороогоороо ороогүй. Тухайн үедээ Төсвийн байнгын хороогоор ороод, шууд Их Хурал руу ороод батлагдчихсан байсан. Тэгэхээр одоо Их Хурал зарчмын хувьд энэ хуулиа ч бодсон хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Цэцийн дүгнэлтийг гэсэн шийд гаргах байх гэж бодож байна. Хэн хариуцлага хүлээх вэ гэсний тухайд бол ер нь цаашдаа бид нар хуулиа л үг, үсгийг нь ягштал баримталж аливаа асуудалд их анхааралтай хандаж явахгүй бол ийм байдлууд гараад байх нь өөрөө туйлын зохисгүй гэдэг дээр л хэлэх байна даа.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Саналтай гишүүн байна уу? Ганболд гишүүн. Ганболд гишүүний.

Г.Ганболд: Би бол Цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй л гэж үзэж байна. Яагаад гэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн бол Их Хурлын гишүүнээс ч гэдэг юм уу, Сангийн сайдаас ч юм уу тийм илүү эрх мэдэлтэй, нууц мэдээлэлтэй хүн биш шүү дээ. Тэр битгий хэл манайд Авлигатай тэмцэх газрын дарга нь байсан ч гэдэг юм уу, Ерөнхийлөгч байсан ч хүн төрийн маш нууцын зэрэглэлтэй харьцаж байсан хүн хүртэл буцаж дэвшиж болоод л байхад яагаад ийм асуудал орж ирснийг би ойлгохгүй байна.

Тэгэхээр зэрэг энэ бол би Цэцийн шийдвэр зөв. Үүнийг хүлээж авах нь зүйтэй байх л гэж бодож байна.

Н.Энхболд: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураана. Дэгээрээ холбогдох заалт тус бүрээр нь санал хураах зохицуулалттай. Ингээд 1 дүгээр санал хураалтыг саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 сарын 27-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Үндсэн хуулийн цэцээс ирсэн томъёоллынхоо дагуу танилцууллаа.

11 гишүүн санал хураалтад оролцож, 8 гишүүн дэмжлээ. Дараагийн санал хураалт.

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 7 сарын 7-ны өдрийн хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд сүүлийн 6 хүртэл жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд гишүүнээр ажиллаж байгаагүй гэсэн 29.3.3 дахь заалт нэмсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх 1 жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх

нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 9 гишүүн дэмжиж, 11-ээс 9 дэмжиж саяын санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 24 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Цэцийн дүгнэлтийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэн танилцуулах вэ? Ойрд манайхаас чинь дүгнэлт, танилцуулгыг хэн байгаа билээ? Сарангэрэл гишүүн танилцуулъя.

Гишүүддээ баярлалаа. Нэгдүгээр асуудал дууслаа. Дараагийн асуудалд оръё. Эхлээд Дэд хороогоо товчхон сонсчихъё. Биш арай өөр юм.

17.18 цаг

Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын талаар Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны мэдээллийг сонсьё.

Өчигдөр Дэд хороо хуралдсан, мэдээллээ бэлдсэн байгаа. Батсуурь гишүүн бас сая чөлөө аваад явсан. Дэд хорооны гишүүн Ганболд танилцуулгаа хийе. Ганболд гишүүнийг урьж байна.

Энэ хоёрыгоо араас нь үргэлжлүүлээд явчихна. Ер нь хоорондоо холбоотой асуудлууд байгаа. Ажлын хэсэг.

Г.Ганболд: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалтад Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороонд сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн талаарх хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг хариуцах ба тус чиг

чиг үүргийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн бэлтгэл ажлын талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороо болон Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонссон болно.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 113 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг санал авах, тоолох, дун гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмж хэрэглэхийг зөвшөөрсөн.

Сонгуулийн ерөнхий хороо, түүний дэргэдэх Мэдээлэл технологийн төвөөс санал авах, тоолох, дун гаргах үйл ажиллагаанд хэрэглэх сонгуулийн автоматжуулсан системийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, сонгуульд бэлтгэх ажлыг Монгол Улсын Их Хурлын дээрх тогтоол болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль тогтоомжид заасны дагуу үе шаттайгаар авч хэрэгжүүлэн техникийн бэлэн байдлыг бүрэн ханган ажиллаж байна.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн автоматжуулсан системийн иж бүрдэлд хамаарах 9 төрлийн багц тоног төхөөрөмжид техникийн үзлэг, засвар үйлчилгээг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан хийж дуусгасан байна.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг шинэчлэн тодорхойлох, эрсдэлт хүчин зүйлийг арилгах зорилгоор Сонгуулийн ерөнхий хорооноос Тагнуулын ерөнхий газарт хүсэлт гаргаж холбогдох зөвлөмжийг авсан. Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн уг зөвлөмжийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны кибер аюулгүй байдлын бодлого, кибер аюулгүй

байдлыг хангах журам, Онцгой байдлын үед мэдээллийн систем, сүлжээний тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг зэрэг бодлогын бичиг баримтуудыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангах, мөрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Сонгуулийн зохион байгуулах үйл ажиллагаанд ашиглах “Сонгуулийн нэгдсэн сан” www.e-election.mn цахим системийг ашиглалтад оруулж, сонгуулийн автоматжуулсан системийн бүх төрлийн тоног төхөөрөмжийн хөдөлгөөний бүртгэл, ашиглалтын мэдээллийн нэгдсэн сан үүсэх боломжийг бүрдүүллээ.

Энэхүү систем нь тоног төхөөрөмжийн ашиглалтын бүртгэлийг цахимаар хөтлөхөөс гадна бүх шатын сонгуулийн хороодод ажиллах төрийн албан хаагчид цахимаар сургалт явуулах, сонгуулийн хороодоос сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад үүсдэг бүртгэлийн ажлыг цахимжуулж, мэдээллийн цахим нэгдсэн сан үүсгэх ач холбогдолтой талаар танилцуулав.

Хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчдийн газруудад VPN сүлжээ тавих болон орон нутагт сүлжээний тоног төхөөрөмж тавих.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.17 дахь хэсэгт сонгогчдын нэрсийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй нэгдсэн сантай байх бөгөөд сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэнэ гэж заасны дагуу сонгуулийн санал авах өдөр сонгогчийн бүртгэлийн нэгдсэн сангаас сонгогчийн бүртгэлийг тулгах, улсын бүртгэлийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох дараах шийдлийг дамжуулан ажиллах. Үүнд :

2200 ширхэг 4G сүлжээний тоног төхөөрөмжөөр холбох боломжтой байна. Уг шийдлийг хэрэгжүүлэн ажиллахад шаардагдах зардал 484 сая төгрөгийг шийдвэрлэх шаардлагатай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.17 дахь хэсэг Сонгогчдын нэрсийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй нэгдсэн нэг сантай байх бөгөөд сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэнэ гэж заасны дагуу уг хуулийн хэрэгжилтийг хангах, гадаад улсад байгаа иргэдийг сонгуульд оролцох саналаа өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын программ хангамжийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлийн нэгдсэн санд бүрэн холбох шаардлага үүссэн.

Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж Дипломат төлөөлөгчийн газрын нийт 49 нэгж байгаа бөгөөд 2024 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 9 нэгжийг холбосон байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын программ хангамжийг Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлийн нэгдсэн санд холбох VPN сүлжээг тавихад Тагнуулын ерөнхий газраас олгосон зөвшөөрөл болон албан ёсны шаардлагыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд шаардлагын дагуу гүйцэтгэлийг дахин шалгуулж уг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Ингэснээр иргэдийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал бүрэн хангагдаж байгаа болно.

Улсын бүртгэлийн байгууллагаас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гадаад улсад байгаа иргэдийг сонгуульд оролцох, саналаа өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор 38 нэгжид ажиллуулах техник, тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх ажиллагааны бэлэн байдлыг хангаж

ажилласан бөгөөд VPN сүлжээ тавих ажилд зарцуулагдах 470.301.330 сая төгрөгийн төсвийг шийдвэрлэн ажиллах шаардлагатай байгаа талаар тус тус танилцуулга хийв.

Дэд хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Ганболд, Батсуурь нар алслагдсан бүс нутагт дэвшилтэт технологи болон утасгүй сүлжээг ашиглах боломжтой эсэх талаар асуулт асууж, саналаа хэлсэн болно.

Анхаарал тавьсанд баярлалаа. Мэдээллийг танилцууллаа.

Н.Энхболд: Баярлалаа. Би ажлын хэсгийн гишүүдийг танилцуулчихъя.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнараран ирсэн байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Бат-Эрдэнэ, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Нийслэлийн цагдаагийн газрын дарга, хурандаа Ганбат, Нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга хурандаа Лхагвасайхан ирсэн үү, ирээгүй байна уу? Сонгуулийн ерөнхий хорооны Санхүүгийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Оюунгэрэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын ахлах Наранцэцэг, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дэд дарга хурандаа Амарсанаа. Түрүүн ирчихсэн байсан. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны тасгийн дарга дэд хурандаа Болор-Эрдэнэ. Ийм ажлын хэсгийн хүмүүс байна.

Энэ хоёр хоорондоо холбоотой асуудал. Тийм учраас үргэлжлүүлээд шууд Дэлгэрнараран даргын мэдээллийг сонсчихъя. Дэлгэрнараран дарга одоо тулгамдаад байгаа асуудлуудаа л ярьчих гол нь. Хийсэн ажлуудаа л заавал сонсох

гэсэн зүйлүүдээ товчхон хэлчхээд, одоо асуудал шийдэх юу байна түүнийгээ л хэлээд явчихъя. 2 номерын микрофон Дэлгэрнараран дарга. 3 номер байна. 3 номер, 2 биш шүү.

П.Дэлгэрнараран: Би хийх танилцуулгаа бичгээр хийгээд ирсэн учраас Байнгын хорооны даргын саналаар нэг дэх болон хоёр дахь асуудлуудаа би бичгээр хүргүүлъя. Энэ бол нэг дэх асуудал бол сонгууль зохион байгуулалттай холбоотой Сонгуулийн ерөнхий хорооноос авч хэрэгжүүлж байгаа ажлын төлөвлөгөө, холбогдох байгууллагуудын үйл ажиллагаа уялдааг хангах, харилцан уялдааг хангаж зохион байгуулах гэсэн нэгдүгээр хэсэг байгаа.

Хоёрдугаар хэсэг бол техник хангамжтай холбоотой цахим төхөөрөмжийг сонгуульд ашиглах тухай танилцуулга байгаа. Үүнийг өчигдөр Дэд хорооны хурал дээр танилцуулсан учраас бас бичгээр та бүхэнд хүргүүлъя. Гурав дахь асуудал бол санхүү, төсөв санхүүтэй холбоотой асуудал байгаа. Үүнийгээ энэ танилцуулгаа та бүхэнд уншиж танилцуулъя.

Сонгууль зохион байгуулах шаардлагатай төсөв, санхүүгийн чиглэлээр

Төсвийн тухай хуульд заасны дагуу тус хорооноос Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах шаардлагатай зардлын төсвийг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан зардлын ангилал бүрээр тооцож нийт 38.9 тэрбум төгрөгийн шаардлагатай зардлын төсвийн төслийг хүргүүлсэн боловчиг уг зардал 17.2 хувиар хасагдаж, 32.2 тэрбум төгрөгөөр батлагдсан юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хуульд заасны дагуу зохион байгуулж явуулахад дараах үндэслэлээр нэмэлт санхүүжилт шаардлагатай болж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 112 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн тойрогт ноогдох мандатын тоог Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн 5 бүсэд хамаарах нийт 13 томсгосон тойргийг тогтоосон. Үүнтэй холбоотойгоор саналын хуудасны дундаж хэмжээ урт болж байгаа нь саналын хуудас хэвлүүлэх зардлын нэмэлт зардал шаардлагатай болж байгаа юм.

Хоёрдугаарт, Улсын Их Хурлын дээрх тогтоолын дагуу саналын хуудаст бичигдэх нэр дэвшигчийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор сонгогчдоос саналаа тэмдэглэх, санал тоолох төхөөрөмжид уншуулахад зарцуулагдах нэгж хугацаа нэмэгдэхтэй холбоотойгоор санал авах, тоолох ажиллагааг зохион байгуулахад сонгогчдод хүндрэл учруулахгүйн байх, санал өгөх сонгогчдын дараалал үүсгэхгүй байх, сонгогчдын тооны өсөлт зэргийг харгалзан санал авах байрыг нэмж бэлтгэх, санал бэлтгэх бүхээгийн хүрэлцээ, нөөцийг нэмэгдүүлэхтэй холбогдсон зардал нэмэгдэж байна.

Гуравдугаарт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар байнгын бус ажиллагаатай бүх шатын сонгуулийн байгууллагад сонгуулийн хороодын ажилтан, мэдээлэл технологийн баг, даамлаар нийт 25951 төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч ажиллана. Энэ бол урьдчилсан байдлаар тооцоо. 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн зүйлийн 19.1.6-д зааснаар бүх шатын сонгуулийн хороонд ажилласан ажилтанд олгосон урамшуулал нь нийгмийн даатгалын шимтгэл ноогдох орлогод хамаарч байна.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн энэхүү зохицуулалттай

холбоотойгоор нэмэлт төсөв хэрэгтэй болж байгаа юм.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.17 дахь хэсгийг өөрчлөн найруулж Улсын ерөнхий бүртгэлийн газар нь сонгогчдын гарын хурууны хээг сонгогчдын нэрийн жагсаалтын нэгдсэн сантай тулган таниулах ажлыг зохион байгуулахаар хуульчилсан. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 116 дугаар тогтоолоор гадаад улсад байгаа иргэдээс 2024 оны 6 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүдэд санал авахаар тогтоосон.

Хуулийн энэхүү заалт, энэхүү зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор санал авах байранд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалт болон Дипломат төлөөлөгчийн газрын үндсэн сүлжээг Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлийн нэгдсэн сантай холбох ажлыг зохион байгуулах зардал шинээр шаардагдаж байгаа юм.

5.Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, сонгуулийн шинэ тогтолцоо, сонгуулийн тойрог, мандат, санал тэмдэглэх заавар, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаа зэрэг онцлог шинэ зохицуулалтуудыг сонгогчдод таниулах, сурталчлах, сонгуулийн зохион байгуулах үйл ажиллагааны талаар сонгогчдыг мэдээлэл хангах арга хэмжээний зардал мөн нэмж шаардагдаж байгаа.

Зургаадугаарт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.10-д зааснаар санал авах байранд санал тоолох төхөөрөмж, сонгогчийн бүртгэлийн техник хэрэгсэл болон саналын хуудас хүлээж авснаас хойш тухайн санал авах байрыг цагдаагийн хамгаалалтад авна. Санал авах байрын хамгаалалттай холбоотойгоор Цагдаагийн ерөнхий газраас санал авах байрын гадна орчныг хянах хяналтын камер байршуулах уг камерыг цагдаагийн байгууллагын теле

хяналтын нэгдсэн сүлжээнд холбохтой холбоотой зардлын тооцоог тус хороонд ирүүлээд байгааг та бүхэнд илтгэж байна.

Ингээд бид бол яг нарийвчилсан тооцоог мөн хавсралтаар та бүхэнд хүргүүлсэн. Тараагдсан байх гэж би бодож байна. Баярлалаа.

Н.Энхболд: Хоёр мэдээлэлтэй холбогдуулаад асуух гишүүн байна уу? Нэрээ өгье.

Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн асууя. Хоёр мэдээлэлтэй хоёулантай нь холбогдуулаад.

Б.Пүрэвдорж: Нэг л юм асуугаадахъя. Тэгэхээр одоо нэг тойрог дээр, 10 нэр дэвшигч, нэг намаас дэвшинэ, тэгээд эвсэл дэвшүүлнэ. Тэгэхээр хамгийн гол асуудал та нар яг энэ сонгогчдынхоо санал асуулгын хуудсаа хэвлэх тал дээр янз янзын вариантууд хэр зэрэг гаргаж байгаа юм? Загварууд нь гаргасан уу? Тэр загваруудаасаа бас бид нарт нэгд, заавал олон нийтэд үзүүлэх хэрэггүй. Энэ Их Хурлын гишүүд нэг иймэрхүү байх юм байна гэдгийг нэг үзүүлэх ямар боломж байна? Энэ дээрээ бас, мэдээж тэр хуудас уншлаа гэхэд нэлээн урт хуудас байх юм бол тэр хуудас чинь тэр нөгөө санал хураах машин дотроо багтах уу, багтахгүй юу? Олон олон асуудлууд байна л даа. Тэрийг чинь харж байж л яримаар байна. Ер нь ямархуу вариантууд гарах нь вэ? Хэд хэдэн вариантуудыг та нар бас нэгэнт та нарын ажил юм чинь хувилбарууд байгаа байх. Тэр хувилбарууд дээрээ ямар ямар хувилбарууд байгаа юм? Түүнийгээ хэлж өгөөч.

Н.Энхболд: Дэлгэрнарэн дарга 3 дугаар микрофон.

П.Дэлгэрнарэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Бид нар саналын хуудасны загварыг удахгүй

батална. Саналын хуудасны загварыг батлахаас гадна бас та бүхнээс зөвлөмж авч, одоо бид нар туршиж үзэж байгаа бид нар ер нь хувилбаруудыг хуульд аль хэсэг бол хөдлөхгүй яг тогтмол байх ёстой вэ, аль хэсэг нь бол бас хөдөлгөөнд орж болох вэ гэдэг яг асуудлыг бүгдийг нь тогтоогоод удахгүй саналын хуудасны загварыг батална.

Ер нь Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд саналын хуудас 2 хэсэгтэй байна гэж ингэж зааж байгаа. Тэгэхээр нэг хэсэг нь бол пропорциональ талынх, нөгөө тал нь мажоритар талынх гэдгийг ингэж зааж өгч байгаа 2 хэсэгтэй. Тэгэхээр бид нар бол энэ 25-ны өдрөөр төрийн аудитын байгууллагууд сонгуульд оролцох хөтөлбөрөө намууд хүргүүлж байгаа.

Тэгэхээр эндээс эхний бараг баримжааг бол бид нар авна гэж тооцож байгаа. Тэгэхээр хэд орчим нам, хэдэн эвсэл сонгуульд оролцох нь вэ? Одоо энэ орж байгаа нам, эвслүүд маань дор хаяж 50 хувьд нь нэр дэвшүүлнэ гэдгийг бас тооцож үзнэ. Энэ хуульд заалттай. Ингээд 100 хувь бас дэвшүүлэх намууд ч мэдээж байгаа. Үүнээс тооцоолоод бид нар бол саналынхаа хуудасны ерөнхий хэмжээг гаргана. Хэт бас их том болох гээд байвал хоёр хэсэгтэй байж болох юм гэж бас бид нар үзэж байгаа. Бүүр 2 саналын хуудас тусдаа. Үүний бас ач холбогдол бас байна.

Яагаад гэвэл мажоритар талдаа буруу тэмдэглэгчсэн бол нөгөө пропорциональ талынхаа 1 хуудсан дээр хийх юм бол пропорциональ талынхаа саналын хуудсыг автоматаар хүчингүй болгоод байгаа. Ийм бас байгаад байгаа учраас бид нар хувааж хийх үү, нэг хуудсан дээр хийх үү, аль тал нь илүү бол хүмүүсийн тэр санал өгсөн байдлыг илүү илтгэж чадах вэ гэдгийг бид нар их тооцоолж ингэж ажиллаж байгаа юм. Энэ 25-ны энэ нэр дэвших байдлын анхны багцааг бас авч байж бид нар бас ярьж

баталъя гэсэн ийм тооцоотой явж байгаа.

Алинаар нь ч хийлээ гэхэд бол саналын хуудас бол доод хайрцагтаа багтана. Нэгээр хийсэн ч, хоёроор хийсэн ч. Ер нь саналын хуудасны энэ хэмжээг аваад хийхэд бид нарын хувьд бол эртхэн баталбал бас энэ сонгогчдод мэдээлэл өгч, энэ дээр ийм хуудаснууд байна, ийм хуудсыг бол ингэж бөглөнө гэдэг сургалт, мэдээллийг явуулах бас хугацаатай байх хэрэгтэй учраас бас бид нар жаахан яаравчилж байгаа юм.

Н.Энхболд: гишүүн тодруулъя асуултаа.

Б.Пүрэвдорж: Би таны хариултаас бүгдийг ойлголоо. Тэгэхээр ер нь тийм батлах хугацаа байж байгаа. Та тогтоол өргөн барилдана тийм үү? Хороо өөрөө шийдэх үү, хороо өөрөө батлах уу? Ер нь тийм, нэгэнт л бид нар бас яг энэ сонгууль зөв явуулах талаар бид нар аль аль улс төрийн хүчин, Улсын Их Хуралд суудалгүй намууд бүгдээрээ нэгдсэн байр сууринд хүрсэн байх ёстой. Тэгэхээр би таныг бол Их Хуралд суудалтай 3 нам дээр, дээрээс нь Их Хуралд суудалгүй намуудад бас тодорхой мэдээллийг энийг өгөөд ийм ийм хувилбар явах юм байна гэдгийг нь бас олон нийт тэр намуудад сайн мэдээлэл өгөөрэй гэдгийг л бас хэлээд байна. Тэгээд тэрний дараа батлаарай. Юмыг хүчээр бас шийдээд тэрний дараа асуудал гараад, үүнээс чинь болоод янз янзын гуйвуулсан, бүтэлгүй гэдэг яриа бас гарчих вий л гэж.../минут дуусав./

Н.Энхболд: Баярлалаа. Тогтохсүрэн гишүүн асууя.

Д.Тогтохсүрэн: Сонгуулийн ерөнхий хороон даргаас асууя.

Тэгэхээр би бол энэ зардлын задаргаа харлаа л даа. Хамгийн их санаа зовоож байгаа асуудал бол энэ сонгогчид санал өгөх асуудал байгаа юм. Өмнө нь нэг сонгогч саналаа өгөхдөө 3 орчим

минутын хугацаа зарцуулдаг байсан юм. Одоо энэ товлосон хоригтой холбоотойгоор 9-10 минут зарцуулах нь гэж тооцохоор харагдаж байгаа юм.

Өөрөөр хэлбэл нэг сонгогчийн санал өгдөг хугацаа 3 дахин нэмэгдсэн. Миний ойлгож байгаагаар бол энэ зардлын тооцоо чинь орж ирж байгаа зардлын тооцоог би санал авах, унших хар машины тоог нэмэгдүүлэх, кабины тоог нэмэгдүүлэх, хэсгийн тоог нэмэгдүүлэх ийм юм орж ирнэ гэсэн чинь таны энэ дотор ийм юм огт алга. Хэдэн хэсгийн хороо нэмэгдэж байгаа юм? Хэдэн санал тоолох машины тоо нэмэгдэж байгаа юм? Кабин доторх санал, дүгнэлтийг хурдавчлах үүднээс би бол ойлгохдоо хуучин 3 кабинтай газар 9 кабинтай болох юм байна гэж ойлгож байгаа байхгүй юу. Гэтэл энэ зардал хаа явна вэ?

Хоёрдугаарт нь Байнгын хороон даргаас асууя. Энэтэй холбогдуулаад энэ Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгсөн ч бай энэ тогтоол батлагдах уу? Энэ дутагдаж байгаа энэ Сонгуулийн хорооны гаргаж байгаа зардал чинь 7.5 тэрбум гэхчхэн байна уу? Тийм байна. 7.5 тэрбум төгрөг шаардлагатай гээд гаргаад ирсэн байна. Энэ 7.5 тэрбум төгрөг дээр Байнгын хороо шийдвэр гаргаад Засгийн газарт чиглэл өгөх юм уу? Засгийн газар нөөцөөсөө гаргах юм уу, яах юм? Энийг хурдан шийдэх ёстой. Ийм 2 зүйлийг асууя.

Н.Энхболд: Дэлгэрнарэн дарга эхлээд хариулчих. Би дараа нь хариулчихъя. 3 дугаар микрофон.

П.Дэлгэрнарэн: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө бид нар зардлынхаа тооцоогоор нийт санал авах байранд байрлуулах бүхээгийн тоогоо 2 дахин нэмэхээр ингэж тооцсон. Сонгуулийн хэсгийн хороо хамгийн сүүлийн ээлжит сонгууль болох 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар улсын хэмжээнд 2087 хэсгийн

хороо байгуулагдаж байсан. Өнөөдрийн байдлаар бол энэ 3 сарын 1-ний дотор хэсгүүд байгуулагдсан. Хэсгүүд байгуулагдахдаа 2188 болж, 101 хэсгийн хороо хэсгээр нэмэгдэж байгаа.

Тэгэхээр бид нар бол гол нь аймгийн төвүүд болон нийслэл Улаанбаатар хотод байгаа энэ хэсгүүдийнхээ тоог нэмж байгаа. Энд хуульд бол 3000 хүртэл гэж байгаа боловчиг бид нар 3000-д хүргэхгүйгээр дээд талын хязгаар нь 2300 байя. Тэгээд тэрийгээ ирцийнхээ проценттой бодоод үзэх юм бол бид нар тэгээд болохгүй бол 2 хос машин байрлуулаад, сургуул, цэцэрлэгийн багтаамж сайтай байруудыг ашиглаад бид нар орон нутгийн засаг захиргаануудтайгаа ярьж байгаа. Ингээд нийслэл Улаанбаатар дүүргүүдийнхээ бүх хүмүүстэй бид нар уулзалтыг зохион байгуулсан. Ингээд хийх юм бол энэ асуудлыг шийдэж болно гэж ингэж үзэж байгаа.

Дээр нь бид нар бол сурталчилгааны зардлыг бол маш сайн нэмэх ёстой, хэрэгтэй байна. Бид нар яг энэ санал хураах асуудлаар бүүр нэг бүрчлэн маш сайн тайлбарласан нугалбарыг өрх бүрд 950 мянган өрх бүрд хүргэх ёстой гэж ингэж үзэж байгаа. Тэгэхдээ бид нар цахим болон бусад радио, телевиз бүх л сувгуудаар энэ сурталчилгааг явуулна гэсэн ийм тооцоотой байгаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүний микрофон өгье. Тодруулъя гэж байна.

Д.Тогтохсүрэн: Юу чинь 3 дахин нэмэгдсэн байхгүй юу. Санал өгөх хугацаа 3 дахин нэмэгдчихээд байгаа байхгүй юу. Би бол энэ сонгуулийн зардлыг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлыг зөвхөн энэ рүү л чиглүүлэх ёстой гэж бодож байгаа. Санал хураах өдөр чинь нөгөө сонгогч чинь 10 минут, 1 сонгогч 10 минут саналаа өгөөд наад юу чинь хүрэлцэхгүй байхгүй юу. Орой 22 цагтаа багтахгүй байхгүй юу. Энийг

багтаахын тулд л та энэ нийслэл болон аймгийн төвүүд дээр хэсгийн хороо нэмэгдүүлэх ёстой шүү дээ. Улсын Их Хурал хаврын чуулганаар ийм л үүргийг өөрт чинь өгсөн.

Гэтэл энэ өөрийн чинь зардлын задаргаа харахтай зэрэг чинь сурталчилгааны зарлага 1.2 тэрбумаар тавьж байх шиг. Шал өөр зардал бичээд байгаа байхгүй юу. Бид нар ойлгохдоо хар машины зардал буюу нөгөө санал тоолох тоног төхөөрөмжийн зардал, тэр хэсгийн хороонд ажиллаж байгаа хүмүүсийн хэсэг нэмэгдүүлсэн зардал, кабины тоог 3 дахин нэмэгдүүлсэн зардлыг л бид нар ярьж өгөх гээд байгаа шүү дээ. Тэгсэн чинь өөрөө 24 оны төсөв батлахад хасагдсан юм гээд.../минут дуусав./

Н.Энхболд: Нэмээд тайлбараа хэлчих. Урьд нь та нар бас нэг танилцуулж байсан шүү дээ. Тэн дотор чинь наад юмнууд чинь би бол туссан гэж бодсон юм. Тодорхой хариулт өгөөч Дэлгэрнаран даргаа. 3 дугаар микрофон.

П.Дэлгэрнаран: Нэмэлт дээр тайлбар өгье. Санал тоолох төхөөрөмжийн хувьд буюу хар машин гэж ярьж байгаа. Энэ тоног төхөөрөмжийн хувьд бол одоо бид нарт энэ сонгуульд 3000 төхөөрөмжийг ашиглана. Энэнтэй холбоотой зардал өнгөрсөн 2023 онд төсвийн тодотголоор шийдэгдээд, бид нар одоо 2180, 2200 хэсгийн хороо хүрсэн чиг бид нар бол энэ төхөөрөмжийн тоо бол хүрэлцээтэй. Үүнийгээ бид нар бол сонгуульдаа бэлтгэх ажлаа хийгээд цаг хугацаанд нь хийгээд, бэлтгээд явж байгаа.

Тэгэхээр энэ төхөөрөмжтэй холбоотой зардлууд бол боломжийн гэж ингэж үзэж байгаа. Гол нь манай зардал бол хэсгийн хороодод ажиллах хүмүүсийн тоо нэмэгдэнэ. Хэсгүүдийн тоо нэмэгдэж байгаа учраас тэр хэсгүүдэд урьд нь бид нар 18000 гаран төрийн албан хаагчид энд ажилладаг байсан бол

одоогийн байдлаар бидний тооцоогоор 25000 хүртэл бид нар нэмэгдүүлнэ.

Н.Энхболд: Санал хураадаг пүүтекний тоо нэмэгдүүлэхээс эхлээд байна шүү дээ. Тогтохсүрэн дарга дахиад нэг тодруулчих.

Д.Тогтохсүрэн: Үгүй ээ, Дэлгэрнаран даргаа би их ойлгомжтой асуугаад байгаа юм. Машин чинь 3000 хүрч байгааг нь би ойлгож байна. Хамгийн гол нь одоо бид нар баталж өгсөн төсөв дээр хэдэн хэсгийн хороо нэмэгдчихсэн юм? Тэр хэсгийн хороо хаана нэмэгдсэн юм, тэрэнд хэдэн төгрөг шаардлагатай юм? Кабины тоогоо хэдээр нэмэгдүүлсэн юм? Өөрөөр хэлбэл санал хураах 6 сарын 28-ны өдөр чинь иргэд чинь 20 цагтаа багтахгүй гадаа саналаа өгөх гээд зогсож байвал яах юм бэ? Энэ л том асуудал байгаа байхгүй юу хамгийн гол нь. Би дахин дахин хэлээд байна шүү дээ. Нэг хүний санал өгдөг хугацаа 3 дахин нэмэгдчихсэн. Хуучин 3 минут өгдөг юм нь одоо 10 минут өгнө шүү дээ наадах чинь. Энийг л яриад байхаар таны энэ зардлын чинь тооцоог харахтай зэрэг шал өөр юм оруулж ирээд байгаа байхгүй юу.

Н.Энхболд: Хариулъя, 3 номер.

П.Дэлгэрнаран: Одоогийн байдлаар бол бид нар урдах ээлжит сонгуулиас 101 хэсгийн хороогоор нэмэгдчихээд байгаа. Энэ нь бол голцуу Улаанбаатар хот, аймгийн зарим нэг төвүүд дээр байгаа. Бид нар 3000 гэсэн тэр тоонд нь хүрэхгүйгээр 2000, яг одоогийн байдлаар Улаанбаатар хотын дундаж бол 2139 гэсэн нэг хэсэгт ноогдох сонгогчдын тооны дундаж бол 2139 байгаа.

Кабинуудын тоог нэмэгдүүлэх асуудлыг бид нар 1 дахин нэмэгдүүлсэн байгаа. Бид нар бол хууль дээр бол 2 буюу түүнээс дээш гэж бид нар. Тэгэхдээ ихэвчлэн бид нар 4-5 кабиннуудыг байрлуулдаг. Тэгэхээр одоо бид нар бол

багтаамж сайтай цэцэрлэг, сургуулиудын байр, бусад төрийн өмчийн байруудыг ашиглаж хийхдээ энэ кабинахаа тоог дахин, нэг дахин нэмэгдүүлнэ гэсэн ийм тооцооллоор хийж байгаа юм. Тэгэхдээ сая энэ дээр гарч байгаа юм бол.../минут дуусав./

Н.Энхболд: Энэ саяын оруулж ирж байгаа зардлын тооцоо юм чинь саяын хэлсэн 2 дахин, 1 дахин нэмэгдүүлнэ чинь 4, 5 байсан бол 10 хүртэл болгох нь байна шүү дээ. Энэ юмнууд чинь тусчихсан юм уу, үгүй юм уу л гээд байна шүү дээ. Хүлээж бай. Дэлгэрнаран дарга асуучих.

П.Дэлгэрнаран: Энэ ингэж байгаа юм. Энд зардлын тооцоон дээр харах дээр яах вэ гэхээр бид нар одоо шаардагдаж байгаа зардлаа тавьчихсан юм. Тэгэхээр уг нь бас суурь бид нарт урьд нь батлагдсан тэр 32.2 тэрбум төгрөг дотор яг үүний зардлууд бас явж байгаа юм.

Н.Энхболд: Пүрэвдорж гишүүн ер нь нэг асуугаад юмнуудаа ойлголтуудаа нэгтгээд авсан нь зөв юм. Пүрэвдорж гишүүн нэмээд 1 минутад асуучих. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр одоо ингээд Улсын бүртгэлээс асуух юм. Одоо жишээ нь хэсгийн хороо дээр байгаа Улсын бүртгэлийн компьютерууд бүгдээрээ оффлайн /offline/ ажилладаг, тэн дээр нь жишээ нь нэг хэсгийн хороон дээр хурууны хээгээр өгсөн хүн дараагийн хэсгийн хороон дээр орчихлоор нөгөөх нь танихгүй, дахиад өөр нэг хаягаар бүртгэлтэй хуруугаа бүртгүүлчихсэн тийм хүмүүс санал өгөөд царцаа маягаар яваад байна гэдэг ийм хардлага ялагдсан намаас нь гардаг байхгүй юу. Тэр нь Улаанбаатар хотод ихэвчлэн байна гэж яриад байдаг.

Тийм учраас ингээд Старлинкийг та нар авч байгаа юм байна. Тэгэхээр энэ бүх хэсгийн хороон дээр байгаа танай компьютерууд бүгдээрээ онлайн горим

дээр ажиллах уу оффлайн /offline/ горим дээр ажиллах уу? Тэрийгээ та нэг тодорхой хэлээд өгөөч. Хэрвээ онлайн байх юм бол янз янзын хардлага чинь арай гайгүй болно л доо. Тэр дээрээ нэг та хариу өгөөч.

Н.Энхболд: Нэг газар саналаа өгчхөөд өөр газар дахиад өгөх боломж цаана байна уу, үгүй юү л гэж санаа нь зовж байгаа юм шиг асуулт байна. Дэлгэрсайхан дарга, 5 номерын микрофон.

Д.Дэлгэрсайхан: Улсын бүртгэл Дэлгэрсайхан асуултад хариулъя. Энэ улсын бүртгэлийн байгууллагын хувьд Сонгуулийн тухай хуулиар хүлээсэн 8 чиг үүрэг байдаг. Энэ дотор хамгийн гол асуудал нь сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, хүргүүлэх, танилцуулах, сонгуулийн өдөр иргэдийг таньж баталгаажуулах энэ асуудал байдаг. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр яг таны асуусан энэ асуултад хариулах маш тодорхой ийм заалт орсон. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20.17-д сонгогчдын нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй нэгдсэн нэг сантай байна гэж ингэж заасан байгаа.

Ийм ч учраас Улсын бүртгэлийн байгууллагаас техник хангамж болон программ хангамж дээрээ онцгойлон их анхаарч ажиллаж байна. Бид нар техник хангамжийнхаа хувьд 3000 техник хангамжийг ажлын бэлэн байдалд оруулсан. Программ хангамжийн хувьд яг таны асуусан ийм хоёр программ хангамж өнөөдөр хийгдэж байна. Онлайн байхад зориулагдаж онлайн байна. Ийм ч учраас яг өнөөдрийн энэ зардал мөнгөтэй холбоотой тодорхой нэг хэсэг нь.../минут дуусав./

Н.Энхболд: Гүйцээгээд хариулчих Дэлгэрсайхан даргаа. 5 номерыг өгчих.

Д.Дэлгэрсайхан: Тийм учраас яг өнөөдрийн урьдчилсан байдлаар 2188 хэсэг байгуулагдсан байна. Энэ 2188 хэсэг

онлайн байна гэж ойлгож болно. Онлайн байна.

Өөрөөр хэлбэл тухайн аймгийн, тухайн сумын, тухайн тойргийн, тухайн аймгийн, тухайн сумын тухайн хэсэг дээр байгаа сонгогч хурууны хэзгээ дараад мэдээллээ оруулахад энэ нь шууд төв сервер дээр тэмдэглэгдээд дараагийн удаа та сонгуулиа өгсөн байна. Өгөх өгөхдөө ийм цаг, минутад ийм газар өгсөн байна гэдэг тэмдэглэгээ яг цагт нь буюу рийл тайм /real time/ ийм хэлбэрээр явагдана. Ингэхийн тулд өнөөдөр оруулж ирж байгаа зардлын бас тодорхой хэсэг нь бүх хэсгүүдийг сүлжээнд холбох энэ сүлжээний бас зардал явж байгаа юм гэдгээ бас хэлмээр байна.

Н.Энхболд: Өөр газар саналаа өгөх боломжгүй гэдэгтээ та дахиад нэг хэлээч албан ёсоор.

Д.Дэлгэрсайхан: Боломжгүй. Өөрөөр хэлбэл программ хангамж энэ дээр хурууны, биеийн давхцахгүй өгөгдлөөр таниад, давхар сервер рүү яг энэ мэдээллээ шийдэж байгаа учраас нэгдсэн нэг сан дээр бүх зүйл ажиллаж байгаа учраас онлайн учраас энэ нэг хүн 2 удаа сонгууль өгөх ямар ч боломжгүй байдлаар зохион байгуулагдана.

Н.Энхболд: Баярлалаа. Гишүүд, Тогтохсүрэн гишүүн асуусан. Одоо бид нар яах юм бэ гэж. Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.5 тээ? 10.5 дээр хэрэв ямар нэгэн шалтгаанаар нэмэлт зардал гарах ийм шаардлага үүссэн бол Сонгуулийн ерөнхий хорооны саналаар Засгийн газар Улсын Их Хуралд саналаа оруулаад Улсын Их Хурал шийднэ гэсэн ийм заалттай байгаа.

Тэгэхээр энэ удаад төсөв бол өнгөрсөн оны 11 сард батлагдчихсан. Сонгуулийн хуулийн дагуу бүсчилсэн тойргуудтай болох тухай асуудал энэ оны, он гараад байгуулагдсан, батлагдсан. Үүнээс болоод зардлын зөрүүтэй асуудлууд гарч байгаа. Тийм ч

учраас өнөөдөр эд нар асуудлуудаа танилцуулаад ийм нэмэлт зардлууд шаардлага болж байна гээд Цагдаагийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо ингээд ярьж байгаа.

Бид нар яах вэ гэхээр өнөөдөр мэдээллээ сонсчихоод, мэдээлэл сонслоо Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс Сонгогчдын нэрийн бүртгэлийн дэд хорооны зүгээс ийм саналууд гарч байна. Тэгэхээр энэ асуудлаар тооцоо хийгээд саналаа Улсын Их Хуралд оруулж ир гэсэн бичгийг Байнгын хорооны зүгээс явуулчихна. Засгийн газар оруулаад ирэнгүүт нь Их Хурлаар бид нар энд шийдэж өгөхөөс өөр арга байхгүй гэж бодож байна. Тоо нь хэд байхыг нь бол гол нь та нар Засгийн газар дээрээ бас ярина биз.

Бидний зорилго бол аль болохоор энэ сонгууль маргаангүй, зохион байгуулалт сайтай, үр дүн нь хүлээн зөвшөөрөгдсөн байлгахын тулд зайлшгүй шаардлагатай зардлуудыг нь нэмж өгөх нь зүйтэй л гэсэн ийм байр суурьтай байх болов уу гэж би бол Байнгын хороо, Улсын Их Хурлыг ч бодож байна.

Үүний түрүүн надаа танилцуулагдаж байхад тэр Цагдаагийнхан бас нэг хэсэг болгон дээр 2 камер тавина энэ тэр гээд. Тэрнийхээ зардалтай холбоотой нэлээн том дүн оруулж ирсэн байсан. Үүнийгээ та нар Засгийн газар дээрээ ярь. Одоо байгаа, урьд нь явуулж байсан хэсгүүд дээр бол камертай хэсгүүд байгаа. Огт камергүй юм шиг бүх газруудад хоёрыг нэмж тавина гэдэг бол чухам ямар байдаг юм бол доо. Үүнийгээ Засгийн газар дээрээ сайн яриарай. Саналаа оруулахдаа тэрийгээ очиж танилцуулаарай, тийм ээ. Тэгж байгаад ороод ирье. Тэрийг нь бид нар тухайн үед нь. Яг тэрийг чинь ярьж байна би. Яг тэрийг чинь ярьж байна.

Манай Байнгын хорооноос шийдвэр хэрэггүй байх л даа шийдвэр гарга гэж. Ийм асуудлууд гарлаа, үүнийг

Засгийн газар өөрийнхөө хэмжээнд шийдээд, тэгэхдээ дахиад саяын үндсэн 3 юм байна шүү дээ. Санал хураалт зохион байгуулалт сайтай байх ёстой тийм ээ? Түүнд нь эргэлзэхгүй хэмжээнд байх хэрэгтэй, эмх замбараатай байх хэрэгтэй. Үүнийг нь тогтоол хэрэггүй, тогтоол оруулбал бид нар Засгийн газраас юм ирсэн хойно Их Хурал руу тогтоол оруулна. Энэ дарааллаар явна.

Цагдаагийнханд нэмж хэлэх юм байна уу? Байна уу? Байхгүй юу. Дэлгэрсайхан даргад нэмж хэлэх юм байна уу?

Санал хэлэх гишүүн байна уу? Алга. Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Нэгдүгээрт, Сонгуулийн ерөнхий хороо тэр санал авах байрны тэр юун дээрээ онцгой анхаарах ёстой шүү. Зүгээр хуучин явж байхад л миний ойлгосноор Улаанбаатарынхан чинь орой 20 цагаас хойш шавчихдаг юм гэнэ лээ шүү дээ. Тийм, аймгийн төв дээр ч тийм байдаг. Тэгэхээр 1 сонгогчийн санал өгч байгаа хугацаа 3 дахин нэмэгдсэн байхгүй юу. Тийм учраас энэ дээрээ би онцгой анхаараад зохион байгуулалт дээрээ гэдэг юмыг хэлж байгаа юм. Танай сонгогчийн санал өгвөл энэ чинь Үндсэн хуулиар олгогдсон хамгийн том эрхийг ямар нэгэн хэлбэрээр хаасан ийм байдал руу орж болохгүй байхгүй юу. Дэлгэрнэран өөдөөс өөр юм яриад болохгүй байгаа юм.

Хоёр дахь юм нь байна шүү дээ Байнгын хороон дарга аа, Энхболд дарга аа хоёр дахь юм нь би ингэж ойлгосон шүү дээ. Өнөөдрийн хурлаас Засгийн газарт чиглэл өгсөн тогтоол гаргах ёстой. Хэрэв өнөөдөр үгүй гэвэл бэлтгэж байгаад дараагийн хурлаас гаргах ёстой. Засгийн газар ингэж байгаа юм байна лээ, би Засгийн газрынхантай ярилцсан. Улсын Их Хурлаас ийм хэмжээний зардал нэмэлт шаардлагатай байна гээд. Байнгын хорооноос ч юм уу манайд тодорхой зардлаа тооцсон чиглэл өгөх юм бол бид нар нөөцийн сангаасаа түр

гаргаад явчихъя. Дараа нь тодотгол намраас бол тэр дээрээ сонгуулийн хороон дээрээ тодотгоод явчихъя гэдэг ийм л асуудал юм байна лээ. Нөөцөө дараа нь тодотгочихъё л гэдэг асуудал байгаа байхгүй юу.

Тийм учраас бол би бол Засгийн газарт нэг чиглэл өгсөн юм уу, ямар ч байсан нэг юм гаргах хэрэгтэй. Тэрийгээ өнөөдөр хэрэв бэлэн бол зардлын тооцоо нь өнөөдөр бэлэн болоогүй байвал дараа дараагийн хурлаараа хэлэлцээд нэг шийдвэр заавал Их Хурлаас гаргаж өгөх ёстой. Сонгуультай холбоотой асуудал гэж бодож байна.

Н.Энхболд: Эцсийн шийдвэр Улсын Их Хурлаас гарна. Засгийн газар манай мэдээллийн дараа Байнгын хороо яаж харьцахаа бид нар хуулийнхаа дагуу харчихъя. Миний бодлоор энэ дээр ярьсан юмнуудаа эд нараас оруулж ирсэн тооцоотой, протоколтойгоо оруулаад тогтоол гэвэл тогтоол хэлбэрээр ингээж ярилцлаа, үүний дагуу арга хэмжээ ав гэсэн чиглэлийг нь өгөөд Байнгын хорооны даргын гарын үсэгтэй албан бичиг явсан ч болох л. Аль аль нь болохгүй юм байхгүй гэж бодож байна. Үүнийг бид нар хуулийнхантайгаа ярьчихъя. Аль түргэн хэлбэрээр нь шийдээд явчихъя гэж бодож байна. Болж байна уу Дэлгэрнаран даргаа?

Сонгуулийн ерөнхий хорооны сонсгол, Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны мэдээллүүдийг сонслоо.

Үүний дагуу Засгийн газарт чиглэл өгнө. Тэрийг нь Засгийн газар аваад Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.5-ын дагуу саналаа ирүүлээд бид нар тэрийг нь үргэлжлүүлээд Их Хурлаар шийдээд явах ийм гарцтай. Аль болохоор үүнийгээ хэдүүлээ хурдан хийцгээе. Та бүхэн тоонуудаа хоорондоо сайн дахиж яриарай. Шаардлагатай гэвэл нэг зөвшилцөж болно.

Түүрүүн Пүрэвдорж гишүүн хэлсэн тэр саналын хуудасныхаа талаар бол тэнд Сонгуулийн ерөнхий хороо дарж сууж байгаад өөрөө ганцаараа л батлах ёстой гэсэн хуулийн заалт байхгүй учраас ийм ийм хувилбарууд байна гэдгийг нь бас Байнгын хороотой юм уу зөвшилцөх ийм боломж бол нээлттэй байгаа шүү гэдгийг бас хэлчихье.

Хоёр мэдээлэл сонсож дууслаа. Баярлалаа Байнгын хорооны гишүүддээ.

Байнгын хорооны хуралдаан дууссаныг мэдэгдье.

17.57 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР